



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/48

Мандалговь

**Охидын эрх ба манлайлал
сургалт зохион байгуулах тухай**

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Албан хаагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Охидын хөгжил, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, манлайллын үр чадварыг сайжруулах зорилгоор "Охидын эрх ба манлайлал" сургалтыг 2020 оны 07 дугаар сарын 26-31-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Охидын эрх ба манлайлал" сургалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, төсвийг 3 дугаар, оролцогчдын бүртгэлийн хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 192 500 (Нэг зуун ерөн хоёр мянга таван зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Чинбат/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж оролцогчдын идэвх оролцоог хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Саранзаяа/, гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны үр дүн, оролцогчдын сэтгэл ханамжийн судалгааг нэгтгэн 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдөр даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Саранзаяа/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



431190095